

# Өсвөр үеийнхэнд зориулсан үйлчлэл, үйл ажиллагааны удирдамж

Эдгээр зарчим болон удирдамж нь үр ашигтай үйлчлэх боломжуудыг болон таатай, хөгжилтэй үйл ажиллагаануудыг хамтдаа зөвлөлдөн төлөвлөхөд нь өсвөр үеийнхэн, насанд хүрсэн удирдагчдад туслах зорилготой. Эдгээр зарчим болон удирдамжийг гадас, тойрог, өсвөр үеийнхний зөвлөлийн хуралд эх сурвалж болгон ашиглаж болно.

## ЗАРЧМУУД

Чуулга, ангийн удирдагчид насанд хүрсэн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаануудыг төлөвлөж, явуулна. Үйл ажиллагаанууд нь:

- Өсөж буй үеийнхний Тэнгэрлэг Эцэгт болон Түүний Хүү Есүс Христэд итгэх итгэлийг хүчирхэгжүүлж, өсвөр үеийнхэн, тэдний гэр бүлд амьдралын сорилт бэрхшээлтэй тулгарсан үед гэрээний замаар урагшлахад тусална.
- Аврал, өргөмжлөлийн ажлыг гүйцэтгэхэд өсвөр үеийнхэнд туслах (*Ерөнхий гарын авлага: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйлчлэх нь* (2020), 1.2, [ChurchofJesusChrist.org](http://ChurchofJesusChrist.org)).
- Чуулга, ангийн эв нэгдлийг бэхжүүлж, үе тэнгийнхэн, удирдагчид, гэр бүлийнхэнтэйгээ харилцаа холбоогоо хөгжүүлэх замаар өсвөр үеийнхэнд дэмжлэг туслалцаа үзүүлж, тэднийг хамруулна.
- Өсвөр үеийнхнийг бусдад үйлчлэх, сүнслэг байдал, нийгэм, бие бялдар, оюун ухааны хувьд өсөж хөгжих адил тэгш боломжоор хангана (*Лук 2:52*-ыг үзнэ үү).
- Залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдэд бурханлаг үүргээ биелүүлэхэд нь бэлтгэхэд туслах туршлагыг бий болгоно.
- Сүмийн аюулгүй байдлын болон өөр бусад бүх бодлого, удирдамжийг дагаж мөрдөнө ([safety.ChurchofJesusChrist.org](http://safety.ChurchofJesusChrist.org)-ийг үзнэ үү).

## УДИРДАМЖ

Орон нутгийн удирдагчдын удирдлаган доор дараах удирдамжийг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно.

- Боломжтой бол, долоо хоног бүр үйлчлэл, үйл ажиллагаа зохион байгуул. Үйлчлэл, үйл ажиллагаануудыг чуулгын болон ангийн гишүүдийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд үндэслэн цөөлж болох ч хамгийн багадаа сард нэг удаа зохион байгуулах ёстой.
- Хуваарийг дор хаяж гурван сарын өмнөөс боловсруулан гаргана. Энэ нь дээрх зарчмууд дээр үндэслэн, зорилго бүхий, хүч чадал сорьсон үйл ажиллагаануудыг чуулга, ангийн гишүүдийн хэрэгцээнд тохируулан төлөвлөх боломжийг олгоно.
- Өсвөр үеийнхэнд зориулан хувь хүн, гэр бүл, нийгэмдээ үр ашигтай үйлчлэх боломжийг эрэлхийл. Хүрэнээсээ гарч үйлчлэхийг урамшуулахдаа чуулга, ангийн гишүүн бүрийн хэрэгцээ шаардлага, ашиг сонирхлыг харгалзан үз.
- Залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагаа нэн ач тустай тул боломжтой бол сар бүр зохион байгуул. Ахлах ангийн насны өсвөр үеийнхэнд зориулсан хамтарсан үйл ажиллагааг ойр ойрхон зохион байгуулж болно.
- Өсвөр үеийнхэнд чуулганд болон аялалд оролцох боломж олго. Тухайлбал:
  - 14 болон түүнээс дээш насны өсвөр үеийнхэн хоёр жилд нэг удаа ӨҮБББТ чуулганд оролцоно. ӨҮБББТ чуулган зохион байгуулагдахгүй жилд өсвөр үеийнхний чуулганыг болон аяллыг хийж болно.
  - Залуу эмэгтэйчүүдийн болон Аароны санваарын чуулгын аяллыг жил бүр зохион байгуулж болно.
  - Хоногоор явах бусад аялал, үйл ажиллагааг мөн адил зохион байгуулж болно. Боломжтой бол, залуу эрэгтэйчүүдийн хувьд жил бүр хоногоор явах гурваас зургаан аялал эсвэл үйл ажиллагаа явуулахыг зөвлөж байна.
- Чуулгын болон ангийн үйл ажиллагаанд зориулсан нэмэлт санаануудыг [ChurchofJesusChrist.org/youth/childrenandyouth/discover](http://ChurchofJesusChrist.org/youth/childrenandyouth/discover) хаягаар орж авна уу. Үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө *Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө* (2011) товхимлыг ашиглана уу.

## ЭХ СУРВАЛЖУУД

- *Ерөнхий гарын авлага*, 10, 11, 20-р бүлэг
- [YoungWomen.ChurchofJesusChrist.org](http://YoungWomen.ChurchofJesusChrist.org)
- [AaronicPriesthoodQuorums.ChurchofJesusChrist.org](http://AaronicPriesthoodQuorums.ChurchofJesusChrist.org)